

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	Error! Bookmark not defined.
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал	10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	10
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	11
3.8 Аудитын гол асуудал	12
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	12
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	12
4. Аудитын илрүүлэлт	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.ТҮВШИНБАЯР



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	8,739,362.00	36,965,525.00
33	АВЛАГА	6,835,325.00	34,635,325.00
335	Бусад авлага	6,835,325.00	34,635,325.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,000,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	6,835,325.00	33,635,325.00
35	БАРАА МАТЕРИАЛ	1,904,037.00	2,330,200.00
354	Хангамжийн материал	1,904,037.00	2,330,200.00
35410	Бичиг хэргийн материал	613,000.00	1,343,200.00
35420	Аж ахуйн материал	457,000.00	687,000.00
35440	Түлш, шатах тослох материал	834,037.00	300,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	187,515,565.69	249,509,580.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	187,515,565.69	249,509,580.71
392	Биет хөрөнгө	119,313,065.69	181,329,580.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	93,139,066.34	155,603,566.34
39202	Хуримтлагдсан элэгдэл	(5,034,544.08)	(7,725,328.62)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	22,900,000.00	22,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(3,833,333.41)	(11,283,333.49)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,660,774.00	31,113,670.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,493,333.20)	(9,835,889.86)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,059,120.00	7,889,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,084,683.96)	(7,332,203.66)
393	Биет бус хөрөнгө	68,202,500.00	68,180,000.00
39301	Програм хангамж	450,000.00	450,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(427,500.00)	(450,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	68,180,000.00	68,180,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	196,254,927.69	286,475,105.71
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	196,254,927.69	286,475,105.71
51	Засгийн газрын хувь оролцоо	196,254,927.69	286,475,105.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	68,180,000.00	68,180,000.00
51101	Өмч: - төрийн	68,180,000.00	68,180,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	87,801,261.47	178,021,439.49
51210	Өмнөх үеийн үр дүн	77,613,870.74	87,801,261.47
51220	Тайлант үеийн үр дүн	10,187,390.73	90,220,178.02
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	40,273,666.22	40,273,666.22
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	196,254,927.69	286,475,105.71

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	192,691,674.00	320,685,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	35,251,274.00	76,844,500.00
120	Нийтлэг татварын бус орлого	35,251,274.00	76,844,500.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	35,251,274.00	76,844,500.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,555,000.00	10,080,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	17,696,274.00	66,764,500.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	157,440,400.00	243,841,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,440,400.00	240,841,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт	155,440,400.00	240,841,400.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	182,579,283.27	230,465,721.98
21	УРСГАЛ ЗАРДАЛ	182,579,283.27	230,465,721.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	164,412,410.09	219,735,600.64
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,506,219.00	150,798,366.30
210101	Үндсэн цалин	93,431,821.60	103,209,757.92
210102	Нэмэгдэл	13,649,597.00	31,621,819.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,068,800.40	12,426,789.00
210104	Урамшуулал	2,356,000.00	3,540,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,106,791.37	18,566,594.95
210201	Тэтгэврийн даатгал	10,464,915.03	13,289,870.89
210202	Тэтгэмжийн даатгал	1,233,159.25	1,470,327.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	956,612.36	1,142,781.88
210204	Ажилгүйдлийн даатгал	226,554.99	242,255.35
210205	Эрүүл мэндийн даатгал	2,225,549.74	2,421,359.20
2104	Хангамж, бараа материалын зардал	11,414,486.23	13,098,260.41
210401	Бичиг хэрэг	3,197,510.00	3,528,150.00
210402	Тээвэр, шатахуун	2,801,963.00	5,077,037.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,708,607.13	3,605,073.41
210404	Ном, хэвлэл	600,000.00	888,000.00
2105	Нормативт зардал	2,478,200.00	2,491,800.00
210502	Хоол, хүнс	2,478,200.00	2,491,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,997,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,000,000.00
210604	Урсгал засвар	-	2,997,000.00
2107	Томилолт, зочны зардал	369,800.00	2,096,000.00
210702	Дотоод албан томилолт	369,800.00	2,096,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,956,661.00	1,649,694.00
210803	Даатгалын үйлчилгээ	569,850.00	569,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,488.00	156,044.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	220,000.00
210807	Газрын төлбөр	426,323.00	681,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,580,252.49	25,037,884.98
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,075,510.00	5,000,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,179,990.00	306,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	7,324,752.49	19,730,484.98
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,166,873.18	10,730,121.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,193,250.00	1,195,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,193,250.00	1,195,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох	16,973,623.18	9,535,121.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,973,623.18	9,535,121.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	10,112,390.73	90,220,178.02
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	9,485,521.42	90,220,178.02

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний
C01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	87,801,261.47	196,254,927.69
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	87,801,261.47	196,254,927.69
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
C07	Тайлант үеийн үр дүн				-
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	87,801,261.47	196,254,927.69
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	87,801,261.47	196,254,927.69
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	87,801,261.47	196,254,927.69
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	90,220,178.02	90,220,178.02
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	68,180,000.00	40,273,666.22	178,021,439.49	286,475,105.71

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	174,995,400.00	253,921,400.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	17,555,000.00	10,080,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	17,555,000.00	10,080,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	17,555,000.00	10,080,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	17,555,000.00	10,080,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	157,440,400.00	243,841,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,000,000.00	3,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	155,440,400.00	240,841,400.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	155,440,400.00	240,841,400.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	174,995,400.00	234,961,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	174,995,400.00	234,961,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	156,828,526.82	197,431,278.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,372,457.32	150,798,366.30
210101	Үндсэн цалин	93,298,059.92	103,209,757.92
210102	Нэмэгдэл	13,649,597.00	31,621,819.38
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9,068,800.40	12,426,789.00
210104	Урамшуулал	2,356,000.00	3,540,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,106,791.37	18,566,594.95
210201	Тэтгэврийн даатгал	10,464,915.03	13,289,870.89
210202	Тэтгэмжийн даатгал	1,233,159.25	1,470,327.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	956,612.36	1,142,781.88
210204	Ажилгүйдлийн даатгал	226,554.99	242,255.35
210205	Эрүүл мэндийн даатгал	2,225,549.74	2,421,359.20
2104	Хангамж, бараа материалын зардал	11,289,117.13	13,145,423.41
210401	Бичиг хэрэг	3,344,510.00	4,109,350.00
210402	Тээвэр, шатахуун	3,636,000.00	4,543,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,708,607.13	3,605,073.41
210404	Ном, хэвлэл	600,000.00	888,000.00
2105	Нормативт зардал	2,478,200.00	2,491,800.00
210502	Хоол, хүнс	2,478,200.00	2,491,800.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,997,000.00
210604	Урсгал засвар	-	2,997,000.00
2107	Томилолт, зочны зардал	369,800.00	2,096,000.00
210702	Дотоод албан томилолт	369,800.00	2,096,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,956,661.00	1,649,694.00
210803	Даатгалын үйлчилгээ	569,850.00	569,850.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,488.00	156,044.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	220,000.00
210807	Газрын төлбөр	426,323.00	681,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,255,500.00	5,686,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,075,510.00	5,230,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,179,990.00	455,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,166,873.18	37,530,121.34
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,193,250.00	27,995,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,193,250.00	27,995,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	16,973,623.18	9,535,121.34
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	16,973,623.18	9,535,121.34
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-	18,960,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	18,960,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	18,960,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	18,960,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	18,960,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(18,960,000.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	Цэвэр гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-
		Батлагдсан төлөвлөгөө		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	247,441,400.0	241,389,278.66	6,052,121.34
21	УРСГАЛ ЗАРДАЛ	247,441,400.0	241,389,278.7	6,052,121.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	219,441,400.0	213,394,278.66	6,047,121.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	151,800,000.0	150,798,366.30	1,001,633.7
210101	Үндсэн цалин	151,800,000.0	103,209,757.92	48,590,242.1
210102	Нэмэгдэл	-	31,621,819.38	(31,621,819.4)
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	12,426,789.00	(12,426,789.0)
210104	Урамшуулал	-	3,540,000.00	(3,540,000.0)
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	20,493,000.0	18,566,594.95	1,926,405.1
210201	Тэтгэврийн даатгал	16,013,000.0	13,289,870.89	2,723,129.1
210202	Тэтгэмжийн даатгал	1,120,000.0	1,470,327.63	(350,327.6)
210203	ҮОМШӨ-ний даатгал	896,000.0	1,142,781.88	(246,781.9)
210204	Ажилгүйдлийн даатгал	224,000.0	242,255.35	(18,255.4)
210205	Эрүүл мэндийн даатгал	2,240,000.0	2,421,359.20	(181,359.2)
2104	Хангамж, бараа материалын зардал	15,752,000.0	13,145,423.41	2,606,576.6
210401	Бичиг хэрэг	4,141,800.0	4,109,350.00	32,450.0
210402	Тээвэр, шатахуун	5,943,200.0	4,543,000.00	1,400,200.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,767,000.0	3,605,073.41	1,161,926.6
210404	Ном, хэвлэл	900,000.0	888,000.00	12,000.0
2105	Нормативт зардал	2,500,000.0	2,491,800.00	8,200.0
210502	Хоол, хүнс	2,500,000.0	2,491,800.00	8,200.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,000,000.0	18,960,000.00	40,000.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	18,000,000.0	17,960,000.00	40,000.0
210602	Тавилга	1,000,000.0	1,000,000.00	-
2107	Томилолт, зочны зардал	2,127,000.0	2,096,000.00	31,000.0
210702	Дотоод албан томилолт	2,127,000.0	2,096,000.00	31,000.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, х	1,744,400.0	1,649,694.00	94,706.0
210803	Даатгалын үйлчилгээ	569,900.0	569,850.00	50.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	156,100.0	156,044.00	56.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.0	22,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	220,000.0	220,000.00	-
210807	Газрын төлбөр	776,400.0	681,800.00	94,600.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,025,000.0	5,686,400.00	338,600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,275,000.0	5,230,900.00	44,100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	750,000.0	455,500.00	294,500.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,000,000.00	27,995,000.00	5,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,000,000.0	27,995,000.00	5,000.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	28,000,000.0	27,995,000.00	5,000.0
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	247,441,400.0	241,389,278.66	6,052,121.3
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	240,841,400.0	231,309,278.66	9,532,121.3
132001	Орон нутгийн төсвөөс	240,841,400.0	231,309,278.66	9,532,121.3
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	6,600,000.0	10,080,000.00	(3,480,000.0)
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,600,000.0	10,080,000.00	(3,480,000.0)
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-		

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Цэвэр гүйцэтгэл	Төсвийн хэмнэлт+, хэмнэлт-
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	3,000,000.0	-	-
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	3,000,000.0	-	-
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	2,997,000.00	-	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,997,000.00	-	-
210604	Урсгал засвар	-	2,997,000.00	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,000.00	-	-
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,000.00	-	-
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,000.00	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	3,000,000.0	-	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	3,000,000.00	-	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,000,000.00	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-		-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-		-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Орон нутгийн өмчийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Говь-Алтай аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Энхдэлгэр гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Ж.Бүжинханд, аудитын менежер Д.Эрдэнэчимэг, дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн 5 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Орон нутгийн өмчийн газар нь Орон нутагт улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны хэрэгжилтийг хангах, орон нутагт худалдан авах ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангах, төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, холбогдох газарт хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх, УИХ, Засгийн газар, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар зэрэг удирдах дээд байгууллагын шийдвэр, үүрэг даалгаврын биелэлтийг тайлагнах ажил үйлчилгээг чиг үүргийн дагуу хэрэгжүүлэх байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Орон нутгийн өмчийн газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн зардлын 185.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 3.7 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувь буюу 2.9 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Орон нутгийн өмчийн газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46 хувиар буюу 90.2 сая төгрөгөөр өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөг, эздийн өмчийн данс байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 2.3 сая төгрөг болж 0.4 сая төгрөгөөр өссөн нь бичиг хэргийн материалын худалдан авалт нэмэгдсэнтэй холбоотой байна. Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 13.7 сая төгрөгийн бараа материал бэлтгэж үйл ажиллагаандаа 13.3 сая төгрөгийн материалыг зарцуулжээ. Оны эцэст 2.3 сая төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 286.1 сая төгрөг болж 77.7 сая төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 18.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэж, 66.8 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авсантай холбоотой байна. Тайлант онд 85.5 сая төгрөгийн хөрөнгийг актлаагүй, 6.9 сая төгрөгийн хөрөнгийн үнэ шинэчлэн тогтоож хасалт хийсэн ба тайлант оны эцэст 286.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Авлага дансны үлдэгдэлд шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговор олгож авлага үүсгэсэн 6.8 сая төгрөг, тайлант хугацаанд дахин цалингийн нөхөн олговор 26.8 сая төгрөгийг олгож, тавилгын үнэ 1.0 төгрөгийг шилжүүлсэн боловч хөрөнгө хүлээн аваагүй авлагаар тусган, тайлант оны эцэст 34.6 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 286.5 сая төгрөг болж 90.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй ба тайлант оны хуримтлагдсан үр дүнгийн эцсийн үлдэгдэл 178.0 сая төгрөг болсон байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 247.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн 1 хөтөлбөрийн хүрээнд 2 арга хэмжээг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр 247.4 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 247.4 сая төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны орлогоос 10.1 сая төгрөг орж, урсгал үйл ажиллагаанд 241.4 сая төгрөгийг зарцуулж 9.5 сая төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 241.4 сая төгрөг буюу 98.0 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 1.9 сая төгрөгөөр, хангамж бараа материалын зардлыг 2.6 сая төгрөгөөр, тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар автомашины засвар үйлчилгээнд зориулж 3.0 сая төгрөгийн санхүүжилт орж, зориулалтын дагуу засвар үйлчилгээнд зарцуулсан.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төрийн албаны зөвлөлийн хийсэн хяналт шалгалтаар Төрийн албаны тухай хууль тогтоомж зөрчиж томилсон 4 албан тушаалтан ажиллаж байна. Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлж, хууль тогтоомж зөрчиж томилгоо хийхгүй байх.

3.8 Аудитын гол асуудал

Тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд Шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 145 мэдээллээс 142 мэдээллийг хугацаандаа мэдээлсэн ба хугацаа хоцроосон 3 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого мөнгөн гүйлгээг байршуулаагүй.

Сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 0.3 сая төгрөгийн төлбөрийн акт, 2.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар төсвийн хэмнэлтийн горимыг баримталж ажиллаж буй эсэхийг үзэх нь зүйтэй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2.4 сая төгрөгийн алдааг залруулж, 32.5 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1 зөвлөмж өгсөн.

4.1 Залруулсан алдаа

Аудитын явцад тайлант хугацаанд 2.4 сая төгрөгийн авлага дутуу бүртгэснийг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй.

4.3 Албан шаардлага

Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг баримтлалгүйгээр 1.0 сая төгрөгөөр тавилга бэлтгэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4 дэх заалт "энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Батлагдсан төсвийг 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар төлөвлөж зарцуулаагүй нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-т "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Шүүхийн шийдвэрийн дагуу нөхөн олговор олгож төсвийг 26.8 сая төгрөгөөр хохироосон нь Захиргааны ерөнхий хуулийн 103.1-т "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай албан тушаалтнаар буцааж төлүүлнэ.", Хөдөлмөрийн тухай хуулийн 132.1-т "Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан ажилтанд сахилгын, захиргааны, эрүүгийн хариуцлага оногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.", Төрийн албаны тухай хуулийн 50.1-т "Төрийн жинхэнэ албан хаагчийг хууль бусаар төрийн албанаас чөлөөлсөн, түр чөлөөлсөн, халсныг төрийн албаны төв байгууллага, эсхүл шүүх тогтоосон бол төрд учруулсан хохирлыг уг шийдвэрийг гаргасан буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлнэ." заалттай нийцэхгүй бөгөөд нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

Тайлант хугацаанд хийсэн 4.7 сая төгрөгийн гүйлгээнд төлбөрийн баримт хавсаргаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" Татварын ерөнхий хуулийн 28.2-т "Татвар төлөгч ногдуулалт хийхдээ энэ хуульд заасан нийтлэг журмыг баримтлах бөгөөд холбогдох хуульд заасны дагуу орлого, зарлагын гүйлгээг бүртгэх, баримтжуулах, цахим төлбөрийн баримт үйлдэх, хэвлэх, илгээх, татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл дамжуулах зориулалт бүхий, нэгдсэн системд холбогдсон, стандартын шаардлага хангасан кассын машин, төхөөрөмж, компьютер, бусад дагалдах хэрэгслийг зориулалтын дагуу бүрэн ашиглаж, борлуулалтын мэдээллийг 14 хоногт багтаан татварын бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд илгээж, бүртгүүлнэ.", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 14.3-т "Албан татвар суутган төлөгч хоорондын бараа борлуулсан, ажил гүйцэтгэсэн, үйлчилгээ үзүүлсэн тухай бүрд төлбөрийн баримт олгох бөгөөд уг баримтуудыг дангаар, эсхүл хамтатган нэмэгдсэн өртгийн албан татварын падаан үйлдэнэ." гэсэн заалттай нийцэхгүй бөгөөд иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Аудитаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Мөнгөн хөрөнгийн данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны цахим хуудсанд цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 68.5 сая төгрөгийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах.

2. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Орон нутгийн өмчийн газар	5	34.9	1	2.4			4	32.5	1	